



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 09 сарын 17 өдөр

Дугаар A/64

Улаанбаатар хот

Г Тушаалыг хүчингүй болгох тухай Г

“Ундны ус хангамжийн ажлын зураг төсөл” /14км, усан сан/ ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажилд шаардлагатай “Ажлын зураг төсөл боловсруулах даалгавар” Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт батлагдахаар хүлээгдэж байгаа тул Газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ундны ус хангамжийн ажлын зураг төсөл” /14км, усан сан/ зураг төсөл боловсруулах ажилд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулсан Газрын даргын 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/52 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

2. “Ундны ус хангамжийн ажлын зураг төсөл” боловсруулах даалгаварыг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраар батлуулах ажлыг түргэвчлүүлж яаралтай зохион байгуулж ажиллахыг Төслийн багийн ахлагч, барилга байгууламжийн инженер /Г.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Албаны дарга /Л.Мөхтуяа/-д даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ



31506C0087